

**ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ БА ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛЧДАД  
ЗОРИУЛСАН МЭДЭЭЛЛИЙН ХУУДАС  
КОРОНАВИРУС 2019 (КОВИД-19) ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ МОДЕРНА  
КОВИД-19 ВАКЦИН, МОДЕРНА КОВИД-19, БИВАЛЕНТ ВАКЦИН (ЭХ ХУВЬ БА  
ОМИКРОН ВА.4/ВА.5) ВАКЦИНЫГ ЯАРАЛТАЙ ХЭРЭГЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ**

**6 САРААС 5 ХҮРТЭЛХ НАСНЫХАНД ЗОРИУЛСАН**

Таны хүүхдэд SARS-CoV-2 коронавирусаар халдварладаг Коронавирус 2019 (КОВИД-19) өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Модерна КОВИД-19 вакцин, Модерна КОВИД-19, Бивалент вакцин (Эх хувь ба Омикрон ВА.4/ВА.5, цаашид "Модерна КОВИД-19, Бивалент вакцин" гэх)-ыг санал болгож байна.

Энэхүү Үйлчлүүлэгч ба Эрүүл Мэндийн ажилтнуудад зориулсан Вакцины Мэдээллийн Хуудас нь зөвшөөрөлтэй Модерна КОВИД-19 вакциныг 6 сараас 5 хүртэлх насныханд хэрэглэх Мэдээллийн Хуудсыг багтаасан.<sup>1</sup>

АНУ-ын Хүнс, эмийн чанарын хяналтын газраас Модерна КОВИД-19 вакциныг дараах тохиолдолд ЯХЗ олгосон:

- 6 сараас 5 насныханд хийх анхан шатны цувралын 2 тун;
- тодорхой төрлийн дархлаа султай болох нь тогтоогдсон 6 сараас 5 настай хүүхдэд хийх анхан шатны цувралын гурав дахь тун.

Модерна КОВИД-19 бивалент вакциныг нь 6 сараас 5 настай хүүхдэд Модерна КОВИД-19 вакцины анхан шатны вакцин хийлгэж дууссанаас хойш дор хаяж 2 сарын дараа нэг удаагийн нэмэлт тунгаар хийх ЯХЗ-ийг ХЭЧХГ-аас хүлээн авсан.

ХЭЧХГ-аас Модерна КОВИД-19 вакцин ба Модерна КОВИД-19 бивалент вакцин нь ХЭЧХГ-аас 6 сараас 5 настай хүүхдэд хэрэглэх зөвшөөрөл олгоогүй.

Энэхүү мэдээллийн хуудас нь танд өнөөгийн КОВИД-19 цар тахлын улмаас танд хүүхэд хийлгэж болзошгүй Модерна КОВИД-19 вакцин ба Модерна КОВИД-19 бивалент вакцины эрсдэл, давуу талуудын талаар ойлгоход туслах мэдээлэл агуулдаг. Хэрвээ танд асуух зүйл байвал хүүхдийнхээ вакцины эмчтэй ярилцана уу.

Модерна КОВИД-19 вакцин ба Модерна КОВИД-19 бивалент вакцины хүн бүрийг хамгаалж чадахгүй байж болзошгүй.

---

<sup>1</sup> Таны хүүхэд 6 настай байсан ч та энэхүү Вакцины мэдээллийн хуудсыг авч болно. Анхан шатны цувралын тун хооронд 5 наснаас 6 нас хүрэх хүүхдүүд аль ч тунг хийлгэх боломжтой: (1) 6- сараас 5 хүртэлх насныханд хэрэглэхийг зөвшөөрсөн Модерна КОВИД-19 вакцин; (2) 6 наснаас 11 хүртэлх насныханд хэрэглэхийг зөвшөөрсөн Модерна КОВИД-19 вакцин.

Энэхүү Мэдээллийн Хуудас цаашид шинэчлэгдэнэ. Хамгийн сүүлийн Мэдээллийн Хуудсыг [www.modernatx.com/covid19vaccine-eua](http://www.modernatx.com/covid19vaccine-eua) вебсайтаас үзнэ үү.

## **ЭНЭХҮҮ ВАКЦИНЫГ ХҮҮХДЭДЭЭ ХИЙЛГЭХИЙН ӨМНӨ ТА ЮУ МЭДЭХ**

### **ХЭРЭГТЭЙ ВЭ, КОВИД-19 ГЭЖ ЮУ ВЭ?**

КОВИД-19 өвчин нь SARS-CoV-2 хэмээх коронавирусаас үүсдэг. Энэ төрлийн коронавирус урьд өмнө гарч байгаагүй. Та вирус тээж буй хүнтэй харьцсанаар КОВИД-19-ийн халдвар авч болзошгүй. Энэ бол ихэвчлэн бусад эрхтэнд нөлөөлж болзошгүй амьсгалын замын өвчин юм. КОВИД-19-ийн халдвар авсан хүмүүст хөнгөн хэлбэрээс эхлээд хүнд хэлбэрийн өвчний олон төрлийн шинж тэмдэг илэрсэн гэж бүртгэгдсэн. Вирусын халдвар авснаас хойш 2-14 хоногийн дараа шинж тэмдэг илэрч болно. Шинж тэмдгүүд доорхийг нэгтгэнэ: халуурах; бие арзайх; ханиах; амьсгалахад хүндрэлтэй болох; ядрах; булчин ба бие өвдөх; толгой өвдөх; үнэртэх болон амтлах чадвараа алдах; хоолой хөндүүрлэх; хамар битүүрэх; нус гоожих; дотор муухайрах; бөөлжих; гүйлгэх.

### **МОДЕРНА КОВИД-19 ВАКЦИН, МОДЕРНА КОВИД-19, БИВАЛЕНТ ВАКЦИН ХООРОНДОО ХЭРХЭН ХОЛБОГДДОГ ВЭ?**

Модерна КОВИД-19 вакцин, Модерна КОВИД-19 бивалент вакцинтай адил аргаар хийгдсэн боловч SARS-CoV-2 Омикрон хувилбараас үүдэлтэй КОВИД-19-өөс урьдчилан сэргийлэх Омикрон бүрэлдэхүүн хэсгийг агуулдаг.

ЯХЗ-ийн дэлгэрэнгүй мэдээлэл авахын тулд Мэдээллийн Хуудасны төгсгөлд буй “Яаралтай хэрэглэх зөвшөөрөл (EUA) гэж юу вэ?” хэсгийг үзнэ үү.

### **ТА ХҮҮХДЭДЭЭ ЭДГЭЭР ВАКЦИНЫ АЛЬ НЭГИЙГ ХИЙЛГЭХЭЭС ӨМНӨ ВАКЦИН НИЙЛҮҮЛЭГЧДЭЭ ЮУГ МЭДЭЭЛЭХ ШААРДЛАГАТАЙ ВЭ?**

Та вакцин нийлүүлэгчдээ өөрийнхөө хүүхдийн эрүүл мэндийн байдлын тухай, доорхыг оруулан мэдэгдэнэ:

- ямар нэгэн харшилтай
- өмнө нь миокардит (зүрхний булчингийн үрэвсэл) эсвэл перикардит (зүрхний гаднах бүрхүүлийн үрэвсэл) зэрэг өвчнөөр өвдөж байсан эсэх
- халуурч байгаа
- цус алдалтын эмгэгтэй эсвэл цус шингэлэгч эм хэрэглэдэг
- дархлаа суларсан эсвэл таны дархлааны тогтолцоог өөрчлөх эм хэрэглэдэг
- өөр ямар нэгэн КОВИД-19-ийн вакцин хийлгэсэн
- тарилгаас шалтгаалан ухаан алдаж байсан

### **ХЭН МОДЕРНА КОВИД-19 ВАКЦИН, МОДЕРНА КОВИД-19, БИВАЛЕНТ ВАКЦИН ХИЙЛГЭЖ БОЛОХГҮЙ ВЭ?**

Доорх тохиолдлуудад таны хүүхдийг эдгээр вакцинуудын аль нэгэнд хамруулахгүй:

- Модерна КОВИД-19 вакцины өмнөх тунг хийлгэсний дараа маш хүчтэй харшлын урвал илэрсэн
- эдгээр вакцины аль нэг найрлагад хүчтэй харшлын урвал үзүүлсэн

## **ЭДГЭЭР ВАКЦИНЫ НАЙРЛАГАД ЯМАР БОДИСУУД ОРСОН БЭ?**

Модерна КОВИД-19 вакцин, Модерна КОВИД-19, Бивалент вакцин нь доорх найрлагатай: мессенжер рибонуклеины хүчил (mRNA), липидүүд (SM-102, полиэтилен гликол [PEG] 2000 димиристойл глицерол [DMG], холестерин, 1,2-дистеароил-сн-глицеро-3-фосфохолин [DSPC]), трометамин, трометамин гидрохлорид, цууны хүчил, натрийн ацетат тригидрат, сахароз.

## **ЭДГЭЭР ВАКЦИНЫГ ХЭРХЭН ХИЙХ ВЭ?**

Модерна КОВИД-19 вакцин ба Модерна КОВИД-19, Бивалент вакциныг таны хүүхдийн булчинд тарилга хэлбэрээр хийнэ.

Анхан шатны цуврал: Модерна КОВИД-19 вакциныг 1 сарын зайтай хоёр цуврал тунгаар хэрэглэнэ. Анхан шатны гурав дахь тунг хоёр дахь тунгаас хойш дор хаяж 1 сарын зайтай тодорхой төрлийн дархлаа султай болох нь тогтоогдсон хүмүүст хэрэглэнэ.

Нэмэлт тун: Дараах тохиолдолд Модерна КОВИД-19, Бивалент вакциныг Модерна КОВИД-19 вакцины анхан шатны вакцинжуулалт дууссанаас хойш нэг удаагийн нэмэлт тунгаар дор хаяж 2 сарын дараа хэрэглэнэ.

## **ЭДГЭЭР ВАКЦИНЫГ ӨМНӨ НЬ ХИЙЖ БАЙСАН УУ?**

6 сар ба түүнээс дээш насны сая сая хүн ЯХЗ-ийн дагуу Модерна КОВИД-19 вакциныг хийлгэсэн. Клиник судалгаанаас үзэхэд 6 сараас 5 хүртэлх насны ойролцоогоор 5,000 хүүхэд Модерна КОВИД-19 вакцины дор хаяж 1 тунг хийлгэсэн байна. Өөр клиник судалгаанаас үзэхэд 4,000 орчим 6-11 насныхан, 30,000 орчим 12 болон түүнээс дээш насныхан Модерна КОВИД-19 вакцины багадаа 1 тунг хийлгэсэн байна.

6 сар ба түүнээс дээш насны сая сая хүн ЯХЗ-ийн дагуу Модерна КОВИД-19, Бивалент вакциныг (Эх хувь ба Омикрон ВА.4/ВА.5) хийлгэсэн. Клиник тандалтаар 18 ба түүнээс дээш насны ойролцоогоор 400 хүн Модерна КОВИД-19, Бивалент вакцинаас Омекрон бүрэлдэхүүнтэй гэдгээрээ ялгаатай бивалент вакцины 1 тунг хийлгэсэн.

## **ЭДГЭЭР ВАКЦИНЫ АШИГ ТУС НЬ ЮУ ВЭ?**

Модерна КОВИД-19 вакцин нь КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлдэг болохыг тогтоосон. ХЭЗ нь SARS-CoV-ий Омикрон хувилбараас үүдэлтэй КОВИД-19-өөс илүү сайн хамгаалахын тулд Модерна КОВИД-19, Бивалент вакциныг зөвшөөрсөн.

КОВИД-19-ээс хамгаалах чадвар үргэлжлэх хугацаа тодорхой бус байна.

## ЭДГЭЭР ВАКЦИНЫ ЭРСДЭЛ ЮУ ВЭ?

Вакцин нь харшлын ноцтой урвал өгөх боломжтой. Хүнд хэлбэрийн харшлын хүнд урвал нь вакцины тунг хийлгэсний дараа хэдэн минутаас нэг цагийн дотор илэрнэ. Энэ шалтгаанаар хүүхдийн вакцин нийлүүлэгч таны хүүхдээс вакцин хийлгэсний дараа түүний биеийн байдлыг хянахаар тус байранд хэсэг хугацаанд үлдэхийг шаардах болно. Хүнд хэлбэрийн харшлын урвалын шинж тэмдэг доорхыг оруулна:

- Амьсгалахад хүндрэлтэй болох
- Нүүр, хоолой хавагнах
- Зүрх хурдан цохилох
- Биеийн бүх хэсэгт тууралт гарах
- Толгой эргэх, сульдах

Модерна КОВИД-19 вакцин болон Модерна КОВИД-19, Бивалент вакцин хийлгэсэн зарим хүмүүс миокардит (зүрхний булчингийн үрэвсэл) эсвэл перикардитаар (зүрхний гаднах салст бүрхүүлийн үрэвсэл) өвдсөн. Энэ хүмүүсийн ихэнхэд нь вакцин хийлгэснээс хойш хэд хоногийн дотор дараах шинж тэмдэг илэрч эхэлсэн. Ийм тохиолдол үүсэх магадлал маш бага. Хэрэв таны хүүхдэд вакцин хийлгэсний дараа, ялангуяа вакцины нэг тунг хийлгэснээс хойш 2 долоо хоногийн дотор дараах шинж тэмдгүүдийн аль нэг нь илэрвэл та яаралтай эмнэлгийн тусламж авах хэрэгтэй:

- Цээжээр өвдөх
- Амьсгал давчдах эсвэл амьсгалахад хэцүү болох
- Зүрх хурдан, жигд бус, дэлсэх мэдрэмж төрөх
- Ухаан алдах
- Хэвийн бус байх, байнга цухалдах
- Хоолны дуршил хэвийн бус болох, муудах
- Хэвийн бус, байнга ядрах эсвэл эрч хүчгүй болох
- Байнга бөөлжих
- Хэвлийгээр байнга өвдөх
- Хэвийн бус, байнга даарах, арьс цонхийх

Вакцины клиник тандалтын үед дараах сөрөг нөлөө бүртгэгдсэн:

- Тариа хийсэн хэсгийн урвалууд: тариа хийлгэсэн гарын тунгалгийн булчирхай өвдөх, хөндүүрлэх, хавдах, мөн улайж, хатуурч хавдах (хатуурах)
- Ерөнхий гаж нөлөөнүүд: ядрах, толгой өвдөх, булчин өвдөх, жихүүдэс хүрэх, дотор муухайрах, бөөлжих, халуурах, үе мөч өвдөх, цочромтгой болох/уйлах, нойрмоглох, хоолны дуршил буурах

Вакцин хэрэглэх зөвшөөрөл авсны дараа доорх сөрөг нөлөө мэдэгдсэн:

- Хүнд хэлбэрийн харшлын урвал
- Чонон хөрвөс (загатнах тууралт/гүвдрүү)
- Миокардит (зүрхний булчингийн үрэвсэл)
- Перикардит (зүрхний гадна талын салст бүрхэвчийн үрэвсэл)
- Вакцин хийлгэсэнтэй холбоотойгоор ухаан алдах

Эдгээр нь вакцины бүх байж болох сөрөг нөлөө биш ч байж болно. Ноцтой ба гэнэтийн сөрөг нөлөө үүсэж болзошгүй. Эдгээр вакцины сөрөг нөлөөг судалж байгаа хэвээр байна.

### **СӨРӨГ НӨЛӨӨ ҮҮССЭН ТОХИОЛДОЛД БИ ЮУ ХИЙХ ХЭРЭГТЭЙ ВЭ?**

Хэрвээ таны хүүхдэд хүнд хэлбэрийн харшлын урвал илэрвэл 9-1-1 утас руу залгах эсвэл хамгийн ойрын эмнэлэгт хандана уу.

Хэрэв таны хүүхдийн сөрөг нөлөө арилахгүй хэвээр байгаа бол вакцин хийлгэсэн байгууллага эсвэл эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчтэйгээ холбогдоно уу.

Вакцины сөрөг нөлөөг **АНУ-ын ХЭЧХГ/ХӨХУСТ-ийн (CDC) Вакцины сөрөг нөлөөний талаар мэдээлэх систем (VCHMS) -д мэдээлэх.** VCHMS-ийн 1-80 0-822-7967 үнэгүй утасны дугаар эсвэл <https://vaers.hhs.gov/reportevent.html> вебсайтад онлайн горимд мэдээлнэ үү. Тайлагналын маягтын #18 хайрцагийн эхний шугамд ”Модерна КОВИД-19 Вакциныг ЯХЗ эсвэл “Модерна КОВИД-19, Бивалент вакцин ЯХЗ гэж оруулна уу.

Түүнчлэн та сөрөг нөлөөний талаар 1-866-MODERNA (1-866-663- 3762) утсаар ModernaTX, Inc-д мэдээлж болно.

Мөн та **v-safe системд бүртгүүлэх боломжтой.** V-safe бол КОВИД-19 вакцины дараах болзошгүй сөрөг нөлөөг тодорхойлохын тулд вакцин хийлгэсэн хүмүүсийг хянах зорилгоор текст мессеж, вебсайтын судалгаа ашигладаг, дурын ухаалаг гар утсанд суурилуулсан хэрэгсэл юм. V-safe систем ХӨХУСТ-ийн КОВИД-19 вакцины аюулгүй байдлыг хянахад туслах асуултууд асуудаг. V-safe системээс КОВИД-19 вакцин хийлгэсний дараа хамрагдагсдын эрүүл мэндэд ихээр нөлөөлсөн гэж мэдээлсэн тохиолдолд ХӨХУСТ-өөс утсаар шууд хяналт тавьдаг. Дэлгэрэнгүй мэдээлэл авахаар [www.cdc.gov/vsafe](http://www.cdc.gov/vsafe) вебсайтад хандана уу.

### **ХЭРЭВ БИ ХҮҮХДЭДЭЭ МОДЕРНА КОВИД-19 ЭСВЭЛ МОДЕРНА КОВИД-19, БИВАЛЕНТ ВАКЦИН ХИЙЛГЭХГҮЙ ГЭЖ ШИЙДСЭН БОЛ ЯАХ ВЭ?**

ЯХЗ-ийн дагуу та вакцинд хамрагдах эсвэл татгалзах сонголт хийх боломжтой. Та хүүхдэдээ эдгээр вакцины аль нэгийг хийлгэхгүй гэж шийдсэн бол энэ нь таны хүүхдэд үзүүлэх стандарт эмнэлгийн тусламжид өөрчлөлт оруулахгүй.

### **МОДЕРНА КОВИД-19 ВАКЦИН БОЛОН МОДЕРНА КОВИД-19, БИВАЛЕНТ ВАКЦИНААС ӨӨР КОВИД-19-ӨӨС ХАМГААЛАХ ӨӨР СОНГОЛТ БАЙДАГ УУ?**

6 сартайгаас 5 нас хүртэлх хүүхдэд зориулсан анхан шатны вакцинжуулалтын хувьд бусад КОВИД-19 вакциныг ЯХЗ-ийн дагуу хийлгэх боломжтой. ХЭЧХГ-аас зөвшөөрөгдсөн КОВИД-19 вакцины анхан шатны вакцин хийлгэсэн 5 настай хүүхдэд нэмэлт вакцинжуулалт хийлгэхийн тулд SARS-CoV-2 Омикрон бүрэлдэхүүн агуулсан бусад бивалент вакциныг ЯХЗ-ийн дагуу хийлгэх боломжтой. Модерна КОВИД-19 вакцин болон Модерна КОВИД-19 вакцины анхан шатны вакцинжуулалтад хамрагдсан 6 сараас 4 хүртэлх насны хүүхдэд зориулсан, ЯХЗ-тэй нэмэлт вакцинжуулалт хувьд цорын ганц вакцин юм.

## **БИ ХҮҮХДЭДЭЭ МОДЕРНА КОВИД-19 ВАКЦИН ЭСВЭЛ МОДЕРНА КОВИД-19, БИВАЛЕНТ ВАКЦИНЫГ БУСАД ВАКЦИНУУДАЙ ХАМТ ХИЙЛГЭЖ БОЛОХ УУ?**

Модерна КОВИД-19 вакцин эсвэл Модерна КОВИД-19 вакциныг бусад вакцинуудтай хамтран хэрэглэсэн мэдээлэл ХЭЧХГ-д хараахан ирээгүй байна. Хэрэв та хүүхдэдээ Модерна КОВИД-19 вакцин, Модерна КОВИД-19, Бивалент вакциныг бусад вакцинуудтай хамт хийлгэх хүсэлтэй бол хариуцсан эрүүл мэндийн ажилтантайгаа ярилцана уу.

## **ХЭРЭВ МИНИЙ ХҮҮХЭД ДАРХЛАА СУЛТАЙ БОЛ ЯАХ ВЭ?**

Хэрэв таны хүүхэд дархлаа султай бол та хүүхдэдээ Модерна КОВИД-19 вакцины анхан шатны гурав дахь тунг хийлгэх сонголт хийх боломжтой. Модерна КОВИД-19 вакцины анхан шатны вакцин хийлгэсэн 6 сараас 5 настай дархлаа султай хүүхдүүдэд Модерна COVID-19, Бивалент вакцины нэг удаагийн нэмэгдэл тун хийх боломжтой. Вакцинжуулалт нь дархлаа султай хүмүүст КОВИД-19-ийн бүрэн дархлаа тогтоохгүй байж болзошгүй тул та КОВИД-19-өөс урьдчилан сэргийлэхийн тулд хүүхдээ үргэлжлүүлэн урьдчилан сэргийлэх хэрэгтэй. Таны хүүхдийн ойр дотны хүмүүс зохих ёсоор вакцинжуулалтад хамрагдах хэрэгтэй.

## **ЭДГЭЭР ВАКЦИН МИНИЙ ХҮҮХДЭД КОВИД-19 ХАЛДААХ УУ?**

Үгүй. Эдгээр вакцин нь SARS-CoV-2-ыг агуулдаггүй тул таны хүүхдэд КОВИД-19 халдаахгүй.


## **ХҮҮХДИЙНХЭЭ ВАКЦИНЖУУЛАЛТЫН КАРТАА ХАДГАЛНА УУ**

Таны хүүхэд КОВИД-19 вакцины эхний тун хийлгэхэд вакцины карт олгоно. Та эргэж ирэхдээ картаа авчрахаа мартаузаарай.

## **НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ**

Хэрэв танд асууж лавлах зүйл байвал вебсайтад зочлох эсвэл доорх утсаар холбогдоно уу.

Хамгийн сүүлийн Мэдээллийн хуудаст нэвтрэхийн тулд доор өгөгдсөн QR кодыг сканердана уу.

<b>Модерна КОВИД-19 вакцины вебсайт</b>	<b>Утасны дугаар</b>
<a href="http://www.modernatx.com/covid19vaccine-eua">www.modernatx.com/covid19vaccine-eua</a> 	1-866-MODERNA (1-866-663-3762)

## **БИ ХЭРХЭН ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ АВАХ ВЭ?**

- Вакцин хийлгэсэн байгууллагаас лавлаж асууна уу
- ХӨХУСТ-д вебсайтад <https://www.cdc.gov/coronavirus/2019-ncov/index.html> холбоосоор нэвтэрнэ үү
- АНУ-ын ХЭЧХГ-ын вебсайтад <https://www.fda.gov/emergency-preparedness-and-response/mcm-legal-regulatory-and-policy-framework/emergency-use-authorization> холбоосоор нэвтэрнэ үү
- Муж эсвэл орон нутгийнхаа нийгмийн эрүүл мэндийн хэлтэстэй холбогдоно уу

## **МИНИЙ ХҮҮХДИЙН ВАКЦИНЖУУЛАЛТЫН МЭДЭЭЛЭЛ ХААНА ХАДГАЛАГДАХ ВЭ?**

Вакцин нийлүүлэгч нь таны хүүхдийн вакцинжуулалтын мэдээллийг танай муж/орон нутгийн харьяа Дархлаажуулалтын Мэдээллийн Тогтолцоо (IIS) эсвэл бусад тусгай тогтолцоонд оруулна. ДМС-ийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг: <https://www.cdc.gov/vaccines/programs/iis/about.html> холбоосоор нэвтэрч авна уу.

## **БИ ЭДГЭЭР КОВИД-19 ВАКЦИН ХИЙЛГЭСНЭЭР ЗАХИРГААНЫ ТӨЛБӨР ТӨЛӨХ ҮҮ?**

Үгүй. Энэ удаа нийлүүлэгч танаас вакцины тунгийн төлбөр авахгүй бөгөөд та зөвхөн КОВИД-19 вакцин хийлгэсэн тохиолдолд вакцин хийлгэсэн болон бусад хураамжийг танаар төлүүлэхгүй. Гэвч вакцин нийлүүлэгчид вакцинд хамрагдсан хүмүүст вакцины захиргааны төлбөрийг аливаа хөтөлбөр, төлөвлөгөөний (хувийн даатгал, Medicare, Medicaid, даатгалгүй вакцин хийлгэгчдэд зориулсан HRSA COVID-19 Uninsured Program) дагуу зохих нөхөн олгох арга зам эрэлхийлнэ.

## **БИ ЗАЛИЛИНГИЙН СЭЖИГТЭЙ ТОХИОЛДЛЫГ ХААНА МЭДЭЭЛЭХ ВЭ?**

ХӨХУСТ-ийн КОВИД-19 Вакцинжуулалтын Хөтөлбөрийг ямар нэгэн байдлаар зөрчсөн тухай мэдээл авсан хүмүүс АНУ-ын Эрүүл мэнд, хүний нөөцийн үйлчилгээний газрын Ерөнхий хянан шалгах хэлтэст 1-800-NHS-TIPS утас эсвэл TIPS.NHS.GOV вебсайтад хандаж мэдээлнэ үү.

## **ХОХИРЛЫН НӨХӨН ТӨЛБӨРИЙН ХӨТӨЛБӨР ГЭЖ ЮУ ВЭ?**

Хохирлын нөхөн төлбөрийн хөтөлбөр (CICP) нь тодорхой эм, вакцин, түүний дотор энэ вакцинаас болж ноцтой хохирсон хүмүүсийн эмчилгээний зардал, бусад тодорхой зардлуудыг нөхөн төлөхөд туслах холбооны хөтөлбөр юм. Ерөнхийдөө вакцин хийлгэснээс нэг (1) жилийн дотор CICP-т өргөдөл гаргах ёстой. Энэхүү хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл [www.hrsa.gov/cicp/ вебсайт](http://www.hrsa.gov/cicp/вебсайт) эсвэл 1-855-266-2427 утсаар холбогдоно уу.

## **ЯАРАЛТАЙ ХЭРЭГЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ГЭЖ ЮУ ВЭ (EUA)?**

Яаралтай Хэрэглээний Зөвшөөрөл (EUA) гэдэг нь КОВИД-19 тар тахал зэрэг нийтийн эрүүл мэндийн онцгой байдлын үед вакцин гэх мэт эрүүл мэндийн бүтээгдэхүүний олдоц, ашиглах боломжийг хөнгөвчлөх механизм юм. EUA нь Эрүүл Мэндийн Алба ба Хүний Үйлчилгээ (HHS)-ээс дэмжигддэг ба КОВИД-19 цар тахлын үед биологийн ба эмийн бүтээгдэхүүнүүдийг яаралтай хэрэглэх баталгааг гаргадаг. Яаралтай хэрэглэх зөвшөөрөл авсан бүтээгдэхүүн нь FDA-аас зөвшөөрөгдсөн бүтээгдэхүүнтэй адил төрлийн FDA-н хяналтад хамрагдаагүй.

АНУ-ын ХЭЧХГ нь өөр ямар нэгэн адил төстэй, батлагдсан, боломжит хувилбар байхгүй гэсэн тодорхой шалгуурыг хангасан тохиолдолд ЯХЗ олгоно. Мөн түүнчлэн АНУ-ын ХЭЧХГ-ын шийдвэр уг бүтээгдэхүүн КОВИД-19 цар тахлын үеэр КОВИД-19-өөс сэргийлэхэд үр дүнтэй, мөн тухайн бүтээгдэхүүний мэдэгдэж байгаа болон боломжит үр дүн нь мэдэгдэж байгаа болон болзошгүй эрсдэлээс илүү их нөлөөтэй гэдгийг шинжлэх ухааны бүх нотолгоонд үндэслэсэн байна. Бүтээгдэхүүнийг КОВИД-19 цар тахлын үед ашиглахын тулд эдгээр бүх шалгуурыг хангасан байх ёстой.

ЯХЗ нь бүтээгдэхүүнийг цуцлах эсвэл хүчингүй болгохоос бусад тохиолдолд (үүний дараа бүтээгдэхүүнийг цаашид ашиглахгүй) яаралтай хэрэглэхийг зөвшөөрсөн КОВИД-19-ийн мэдэгдлийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

Moderna US, Inc.  
Cambridge, MA 02139

©2022 ModernaTX, Inc. Бүх эрх хамгаалагдсан.

Патент(ууд): [www.modernatx.com/patents](http://www.modernatx.com/patents)

Хянасан: 2022/08/31



Энэхүү Мэдээллийн Хуудсыг вакцинд хамарсан хүмүүсийн эрүүл мэндийн цахим бүртгэл/дархлаажуулалтын мэдээллийн тогтолцоонд оруулсныг батлахаар скан хийж үзнэ үү.

ББГДТ: 0886983000516